

**“Дэлүү идвэл дэлбэ ниргэ...” хэлц үгийн утга, соёлын онцлогийг
угсаа хэл шинжлэлийн үүднээс тайлбарлах нь**

Лувсанцэрэнгийн Цэрэнчимэд 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Монгол хэлний
тэнхимийн багш, доктор (Ph.D), Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2024-10-24

Засварласан - Revised:
2024-11-30

Хэвлэгдсэн - Published:
2024-12-30

tserenchimed@msue.edu.mn

ORCID: [0000-0001-6741-5858](https://orcid.org/0000-0001-6741-5858)



© 2024, Author(s)

Хураангуй: Монголчуудын хэл, аялгуун дахь хэлц үг, тогтвортой нэгжийн олонх нь нүүдлийн соёл, мал аж ахуйгаас үүдэлтэй заншил, зан үйлд хамаардаг. Мөн угсаатны гарал, овгийн нэрийг тайлбарласан домог, аман мэдээнд өгүүлсэнтэй холбогдох нь байна. Тус өгүүлэлд монголчуудын дунд түгээмэл хэлэлцдэг дурдсан хэлц үг, түүний хувилбарын утга, соёлын онцлогийг угсаа хэл шинжлэлийн онол, арга зүйгээр тайлбарлав. Судалгааны хязгаарлагдмал талыг тус хэлц үгийн хүрээгээр тогтоож, угсаатны зүйчдийн цуглуулсан хээрийн шинжилгээний тэмдэглэл, монголчуудын зан заншлын тайлбар толь бичгийн баримт, зарим аман мэдээнд тулгуурлалаа. Монгол угсаатны зарим овог (хамниганы жишээгээр)-ийн эдийн соёл, оюуны соёлын илрэл болох шүтлэг бишрэл, угсаатны соёл-заншлын аман домгийн холбооноос хэвшиж тогтсон үг, хэллэг эдүгээ гол төлөв цээрлэх ёс, бэлгэдлийн утга илэрхийлдэг хэлц үг болж дэлгэрсэн нь судалгааны ажиглалт, үр дүнгээс харагдав.

Түлхүүр үг: угсаатны хэл-соёл, цээрийн ёс, нүүдлийн ахуй соёл, угсаатны овгийн нэр

Удиртгал

Монголчуудын оюуны ба эдийн соёл, түүнд холбоотой хэлний тогтвортой нэгж буюу хэлц үгийн утга, хэрэглээний онцлогийг мөшгөн үзэхэд ямар нэг байдлаар угсаатны түүх, амьдралын явцад бүтээсэн соёл, ёс заншил, зан үйл, цээр, бэлгэдлийн ёстой холбогдох нь цөөнгүй. Аливаа угсаатан, ялангуяа, монголчуудын хэл, аялгуун дахь хэлц үг, тогтвортой нэгжийн олонх нь нүүдлийн соёл, мал аж ахуй, эдгээрээс үүдэлтэй ёс заншил, зан үйлтэй холбоотой төдийгүй монголчуудын угсаатны бүлэг, овгийн нэрийн үүсэл гарлыг тайлбарласан домог, аман яриатай ч холбогддог. Угсаатны хэл шинжлэл нь хүмүүнлэгийн ухааны нэг салбар бөгөөд энэ чиглэлийг онолын үндэстэй бие даасан дэг сургууль болгон хөгжүүлэхэд Орос, Польш, Герман, Америкийн эрдэмтэн судлаачид чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг. Энэ салбарын гол төлөөлөгчийн нэгд угсаа хэл шинжлэлийн онолын үндсийг боловсруулж, славян ард түмний хэл, соёлын жишээгээр угсаа хэл шинжлэлийн цогц бүтээл туурвисан орсон эрдэмтэн Н.И.Толстой зүй ёсоор тооцогдоно. Мөн Польшийн угсаа хэл шинжлэлийн дэгийг үндэслэгч Ежи Бартминский, АНУ-ын антропологийн салбарыг хөгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн эрдэмтэн Ф. Боас, Э. Сапир, Б. Ворф нарыг онцлон дурдаж, тэдний бүтээлийг онолын үндэс болгодог.

Э.Сапир хэл-соёлын харилцан хамаарал, харьцангуй байдлын талаар санаа дэвшүүлж, хожим Сапир-Воорфын таамаглал нэрээр алдаршсан билээ. Энэхүү таамаглал нь хэл, сэтгэлгээ хоёрын холбооны тухай бөгөөд хэлийг судална гэдэг бол тухайн соёлыг хэрхэн оршиж байгааг судлах гэсэн агуулгатай (Бум-Очир.Д., Мөнх-Эрдэнэ. Г, 2018, р. 72). Тус таамаглалыг өрөөсгөл хэмээн дараа үеийн судлаачид янз бүрийн санал дэвшүүлсэн нь бий. Гэсэн хэдий ч хэл-сэтгэлгээ,

хэл-соёлын холбоо, хамаарлыг үндэстэн, угсаатны хэл-аялгууны олон баримтаар нотлон харуулсан. Угсаа хэл шинжлэл нь “хэл шинжлэл, социологи, угсаатны зүй”-н зааг дахь салбар ухаан. “Угсаа хэл шинжлэл нь хэл ба угсаатны харьцаа холбооны асуудлыг судалдаг. Сэтгэц хэл шинжлэлд хэл ба хүний сэтгэцийг, хавсарга хэл шинжлэлд хэл ба хүний практик үйлийг, нийгэм хэл шинжлэлд хэл ба хүний нийгмийн харьцааг авч үздэг шиг хэл ба угсаатны холбоо харьцааг судалдаг гэсэн үг” (Толстой Н.И., Толстая С.М., 2013, р. 19) хэмээн тайлбарласан юм. Манай улсад угсаатны зүй, хэл шинжлэл, нутгийн аялгуу, аман зохиол, домог зүй-бэлгэдэл, цээрлэх ёс, танихуйн хэл шинжлэл ба хэлний соёл судлал гэх мэт чиглэл бүрээр суурь судалгааны бүтээл хэдийн гарсан. Цаашид эдгээр бүтээл, тэнд буй баримт, хэрэглэгдэхүүнийг суурь болгож, угсаатан судлалын арга зүйд тулгуурлан, тодорхой угсаатны бүлгийн эдийн ба оюуны соёлын өвөрмөц онцлогийг хэл, аялгуу-соёлын холбоонд нь судлан шинжлэх боломжтой юм.

Үндсэн хэсэг

Өнөө цагт хэл, соёлын аливаа үзэгдлийг хүнээс тусад нь салгаж (“хүн төв”-тэй) үзэх учир дутагдалтай болсон нь нэгэнт тодорхой болсон тул хүнийг судалдаг салбар ухаануудын судалгааны арга зүйг угсаа хэл шинжлэлд ч мөн ашиглаж байна. Хүнийг судалдаг шинжлэх ухаанууд, ялангуяа, антропологи хэлийг нийгмийн ба соёлын хүрээнд нь судалдаг бөгөөд АНУ-д 1. нийгэм, соёлын салбар, 2. биологийн салбар, 3. хэл шинжлэлийн салбар, 4. археологийн салбар гэсэн дөрвөн салбарт хуваадаг. Хэлийг судлах антропологийн хандлагад “Сапир-Ворфын таамаглал”, “нийгэм хэл шинжлэл”, “дүрслэх хэл шинжлэл”, “түүхэн хэл шинжлэл” гэсэн дөрвөн салбарыг дурдаад, тус бүрийг товч тайлбарлажээ. Манай улсын хэл шинжлэл, магадгүй, түүхэн болоод дүрслэх хэл шинжлэлийн аргыг түгээмэл ашиглаж буй болов уу. Нэмээд нийгэм эсвэл угсаа хэл шинжлэлийн хандлагаар хэлийг судалж үзвэл сонирхолтой үр дүн гарах нь гарцаагүй юм (Мөнх-Эрдэнэ Г., Чулуунбат П., 2024, р. 192) гэжээ. Хэлний тодорхой үзэгдлийг тайлбарлахад угсаатны бүтээсэн соёл, түүхэн үйл явдал, улс төрийн харилцаа, аман хууль зэргийн аль нэгээс хариулт олохыг үгүйсгэхгүй. Эрдэмтэн Н.И.Толстой “славян үндэстний ардын соёл, бүс нутаг хийгээд нутгийн аялгуунуудын хэлбэрт тулгуурлан, өвөг славяны угсаатны байдлыг сэргээн тогтоосон. Ингэхдээ, уламжлалт соёлыг судлах гол эх сурвалж бол хэл; соёл бол байгалийн хэл (хүний хэлийг машины хэл, хиймэл оюун ухаан зэргээс ялгасан нэр)-тэй адил дохио тэмдгийн тогтолцоо; угсаа хэл шинжлэлд хэлний газар зүйгээс эхлээд хэлний сэргээн тогтоолт, утга зүй болон өгүүлбэр зүй, прагматик хэл шинжлэлийн үзэл баримтлал, арга, хэлэхүйн үйлдлийн онол, танихуйн хэл шинжлэл, концептуал шинжилгээ зэрэг хэл шинжлэлийн олон ойлголт, арга зүйг ашигладаг” гэсэн хэдэн шинжийг нэрлэснийг нэгтгэн тоймложээ (Руденко, 2014, р. 50).

Угсаа хэл шинжлэл хэлний бүх тал, ялангуяа, аман хэлбэр (*аман зохиол, нутгийн аялгуу, хотын хэл, зүйр цэцэн үг гэх мэт*) болон олон төрлийн бичгийн эхийг судалгааны объект болгодог. Угсаа хэл шинжлэлийн гол зорилго нь угсаатны янз бүрийн бүлэг, давхаргын хэлний олон янзын нөхцөл байдлын хэрэглээг шинжлэх явдал юм (Хроленко, 2012, р. 9) гэсэн байна.

Түүнчлэн, “угсаа хэл шинжлэлд *угсаатны гарал үүсэл*, ард түмний түүх, газрын төрх байдал (ландшафт)-ын түүх, хос хэлний судлал, хэлний байдал, хэв шинж, хэлний бодлого, хэлний тухай хууль, хүний эрх, хэлний төлөвлөлт зэрэг хэл шинжлэлийн бус асуудлыг авч үздэг” (Герд, 2005, р. 124) гэжээ. Бидний авч үзэж буй хэлц үгийн утга, соёлын онцлогийг тайлбарлахад хэлний бус хүчин зүйл буюу угсаатны гарал үүсэл, аман зохиол зэрэг судалгааны объект, асуудал гол нөлөөтэй байгаа тул дээр дурдсан онол, арга зүйг үндэс болгож байна.

Энд өгүүлж буй “Дэлүү идвэл дэлбэ ниргэ” гэсэн хэлц үг монгол ёс заншлын тайлбар толь, ном бүтээл, хэлц үгийн тайлбар толь бичигт ч тэмдэглэгдсэн байх бөгөөд монголчуудын дунд гол төлөв цээрлэх ёсны зүйлд хамаатуулж ойлгодог. Гэвч, юуны улмаас, ямар учраас энэхүү үгийг хэлэлцэх болсныг тодруулахын тулд тус хэлц үгийн анхдагч үүсэл, хувьсал хөгжлийг

угсаатан судлалын тэмдэглэл, аман баримт болон хэвшмэл хэлц үгийн тольд тэмдэглэснээс сурвалжлан харъя.

“Дэлүү идвэл дэлбэ ниргэ...” гэсэн хэлц үг:

“Дэлүү идвэл дэлбэ ниргэ

Сархинаг идвэл салба ниргэ”

“Олгой идвэл олби ~ (ойтол) ниргэнэ

Дэлүү идвэл дэлбэ~ (дэлбэртэл) ниргэнэ” зэрэг тэгш хэмт өгүүлбэр бүхий хувилбаруудтай.

Монгол хэлний өгүүлбэрийн бүтцийн талаас хэлэх аялгаар зэрэгцсэн, төсөөт бүтэцтэй, ойролцоо санаат өгүүлбэрүүд болно. Нийлмэл өгүүлбэрийн бүтцийн энэ хэв маяг тогтвортой хэллэгт зонхилдог. Энэ хэлц үгийн утгын онцлогийг хэл-соёлын холбоонд нь тайлбарлахад хамниган угсаатан бүрэлдсэн түүхэн үйл явцын талаарх судалгааны баримт дурдах нь зүйтэй. Академич Б.Ринчен: “Монгол хамниган дотор нэлээд хэдэн овог бий. ...Хамниган угсаатны хүн амын тоо асар олонгүй, сайндвал хошоод гурваад мянган хүнээс хэтрэхгүй атал ийм цөөн угсаатан дотор дал гаруй овог байгаа нь бидний сураглан магадалж, бүрэн гүйцэд тэмдэглэж амжаагүй овог бас энэ цэсэнд ороогүй хоцорсон байж болох бөгөөд эдгээр олон овог, зарим нь жинхэнэ хамниган, зарим нь эртний уугал монгол овог байгаа нь хамниган угсаатны бүрэлдэхүүнд хамниган бус монгол угсаатан бас хутгалдан оролцсон өнгөрсөн түүхийн гэрч болно” гэж тэмдэглээд, хамниган өтгөсийн аман цомог тэмдэглэсэн зарим мэдээ, баримт (тугчин, гүнээкэн, гуринка зэрэг овгийн нэрийн тухай) дурджээ (Ринчен, 1968, р. 32). Энд өгүүлснээс, монгол овог угсаатан түүхийн урт хугацаанд нүүдэл суудал, улс төрийн байдал, дайн тэмцэл, үймээн самуун гэх мэт олон хүчин зүйлийн нөлөөнөөс ихээхэн холилдон байсны нэг жишээг харж болно. Дурдсан хэлц үгийг хэлэлцэх болсон учир, уламжлалыг мөшгин үзэхэд, явсаар монгол угсаатны бүрэлдэхүүн “хамниганы доторх овгийн нэрийн тухай болон хамниганчуудын тэнгэр шүтлэг, аянга цахилгаан тэнгэрийн дууны аюулаас сэргийлж ирсэн байдал”-тай холбоотой байх тун магадтай. Энэ мэт зан үйл, соёлын илрэл нь ард олны дунд амнаас ам дамжаар, уран сэтгэмжээр баяжин, дараа үеийнхэнд домог үлгэр мэт сэтгэгдэн, уламжилсан байж болно. Өөрөөр хэлбэл, аман яриа, хууч яриа зэрэг нь он цаг алсрах тусам өгүүлэмж, үйл явдлын талаар нэг бол баяжин дэлгэрэх эсвэл гээгдэн хураагдсаар үлгэр домог мэт болж уламжилдаг гэсэн үг. Энэ тухай: “Түүх домгийн хөгжил бол нарийн будлиантай өнө удаан хугацааны үйл явц болно. Түүх домгийн үйл явдал нь нийгэм улс төрийн шинжтэй бөгөөд ард олны түүхийн ухамсрыг сэрээж, ... угсаатны соёл, ёс заншил зэргийг сануулж, үндэсний ижилслийг бүтээхийг зорьсон байдаг” (Нандинбилэг. Г., Дулам. С., 2020, р. 18) гэжээ. Тус өгүүлэлд тайлбарлаж буй хэлц үг угсаатны гарвал түүх, соёл заншлын түүх домогт холбогдох бөгөөд дараах хэдэн зүйл баримтаас утга, соёлын онцлогийг тодруулья.

Угсаатны зүйчид, хамниганы цөөнгүй овгийнхонд уламжилсан тэнгэрээс буусан лууг өргөж гаргаснаар овгийн нэрээ авсан тухай өгүүлдэг аман баримт (түүх домог) хээрийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүнд тэмдэглэн үлдээсэн байдаг. Академич Б.Ренчин 1965 онд Дагаанхан хамниган хүний ярьсан (Дорнод. Баян-Уул сум) үүнтэй төстэй аман домог тэмдэглэснийг Б.Нацагдорж судалгааны өгүүлэлдээ эшилж, тайлбарласнаас үзэхэд бороотой үед Үзөөн айл Дагаанхан хүнийг гэртээ байлгаж, болзошгүй аянга, цахилгааны аюулаас сэргийлдэг байсан тухай өгүүлжээ. Мөн “Эртний бөөгийн шүтлэгийн үлдцээс бас тэнгэр дуугарахад хамниганы Дагаанхан овогт хүн ‘Би Дагаанхан хүн энд байна’ гэж гэр дотроос өндөр дуугаар хашхиран дууддаг байсан байна. Хамниган дунд Дагаанхан овогт хүн байсан газар ‘тэнгэр ниргэдэггүй’ гэж үздэг байсан учир Дагаанхан хүнийг хонож өнжүүлэх гэдэг заншилтай” (Нямбуу, 2023, р. 63) хэмээх домог хамниганы ёс заншил хэсэгт тэмдэглэжээ. Дурдсан баримтуудаас хамниган болоод бусад монгол угсаатны шүтлэг бишрэл, байгаль дэлхийг аргадах, өөрсдийгөө аюул ослоос хамгаалах, дээд тэнгэртэй харьцдаг байсан зан үйлийн улбаа энэ хэлц үгэнд туссан нь зарим талаар тодорхой болж байна. Үүнийг лавшруулан үзвэл, адил төстэй

өгүүлэмж бүхий дараах домог Дорнод аймгийн Дашбалбар сумын харьяат Ганжуур Бүүвэй¹ гуай ярьсныг:

“Манайх урианхай овогтой. Тиймээс бид чинь тэнгэр дуугарахаар “Урианхай ээ!” гэж хаширдаг. Тэнгэр дуугарахыг луу дуугарч байна гэдэг. Луу их догширно. “Олгой идвэл олби ниргэнэ. Дэлүү идвэл дэлбэ ниргэнэ.” гэж хэлж байна. Иймээс бид олгой, дэлүү иддэггүй.” (Тангад, Монголын угсаатны зүйн хээрийн судалгаа. IY боть, 2014, р. 298) тэмдэглэжээ.

Тус домгийг ярьсан Бүүвэй гуайн охин, ахмад багш Уранцэцэгээс² энэ тухай асууж тодруулсан юм.

“Миний ээж Бүүвэй, Тавхаан гэдэг айлын таван басаган (охины)-ы нэг байсан. Одоогийн ОХУ-ын Буриад Улсын Өвөр Байгалын хязгаар, Дундговь аймгийн Тугшан (Тугчин) тосгонд 1906 онд төрсөн. Урианхан хамниган омогтой гэдэг. Зарим хүн урианхай гэхэд нь ээж “-хай” биш “-хан” тэгээд “урианхан шүү” гэж их залруулна аа! Ээж минь дүү охиноосоо үрчилсэн тул намайг их энхрийлдэг байлаа. Дэлүү байтугай олгойтой цус ч идүүлдэггүй. Айлууд хонь төхөөрч, гэдэс чанахад нь идмээр санагдана. Сургуулиа төгсөөд багш болж, хадамд очсоны хойно олгойтой цус, гэдэс дотор цээрлэхгүй иддэг болсон сон. Хадмууд маань хорийн буриад (...) омгийн айл байсан тул хонины гэдэс дотор цээрлэдэггүй.” (Л.Цэрэнчимэд. 2023 оны 1-р сард хийсэн ярилцлага).

Дээрх баримтаар бол энэ хэлц үг хамниганчуудын итгэл бишрэл, лууны тухай домгийн өгүүлэмж, тэнгэрийг аргадах ёстой холбоотой бөгөөд тус домгоос хэвшсэн байх гэсэн таамаглалаа баталгаажуулж болно. Ямартаа ч эрт цагаас нааш байгаль ертөнцтэй харьцаж ирсэн заншил, шүтлэг бишрэл, нөгөө талаар, хамниганчуудын ахуй амьдрал, эрхэлдэг аж ахуйгаас үүдсэн цээрийн ёстой холбоотой гэж үзэх үндэстэй юм. Тухайлбал: Ортон хамниган Гомбын Зундуйн өгүүлсэн хамниган ардын нэг дуунд:

“Хохиргоо модны дунд

Өөлэй охин минь

Хонины дунд шинкюк(шинхэг)-тэй

Мих (мах) яаж иднэ вэ?” гэсэн нь эх хүн охиноо талын монгол хоньчин айлд бэр болох гэвэл дуулдаг байсан (Тангад, Монголын угсаатны зүйн хээрийн судалгаа. IY боть, 2014, р. 293). Ер нь ойн иргэд ангийн соёлтой, тураг ангийн мах хүнсэндээ хэрэглэдэг байсан зэрэг эдийн соёлын улбаанаас малын дотор мах идэхийг төдийлөн таашаадаггүй байсан болов уу.

Эдгээр заншилтай холбогдуулан, судлаач Б.Нацагдорж: *“ганц хамниган бус халхын зарим овгийнхны дунд хэлэлцдэг байсан аман домгийн баримт, судалгааны хэрэглэгдэхүүнд тулгуурлан, дотоод Азийн эх газар бол эрс тэс уур амьсгалтай тул аянга цахилгааны аюулаас сэрэмжлэх, хор уршигийг арилгахыг хичээдэг зан үйл монгол газарт их эртнээс бий болсон. “Тэнгэр дуудах” энэ онцгой зан үйлийг эрхэлдэг хүмүүс өөрсдийгөө тэнгэрээс гаралтай гэж үздэг байсан байна”* (Нацагдорж, 2021, р. 124) гэж дүгнэжээ. Улмаар, “Даганагад”, “Дуутан” зэрэг овгийнхны аман мэдээ, баримтад тулгуурлан сонирхолтой гаргалгаа хийснийг дурдсан эх сурвалжаас дэлгэрэнгүй үзүүштэй. Энэ бүгд эцэстээ: “Манай ард түмэн бэлгэдэл эрхэмнэлийн гүн бат язгуур үндэстэй. Тодруулбал, домог зүй нь уялдаа холбоо бүхий домгуудын үргэлж, цул, бүхэл бүтэн нэгдмэл тогтолцоо байсан бөгөөд домог тус бүр нь дагалдах ритуал зан үйлтэй байсан аж. Жишээ нь: тэнгэрээс бороо хур гуйж ерөөл хүслээр хандахын сацуу бороог “хийдэг” байжээ. Энэ нь салхи, үүл, тэнгэрийн нүргэлэх дуу, гялбах цахилгаан, бороо хурыг дүрслэн харуулсан тайзчилсан ритуал зан үйл хийх явдал юм. “Бороо орохгүй бол ургамал гандан хагдарч, хүмүүс зовж шаналан,

¹ Судлаачийн тэмдэглэснээр эшлэв. Залруулах нь: Овог нь Ганжуур биш Тавхаан юм. Охин Уранцэцэгээс нягталж асуув. Мөн тус сумын өрхүүдийн ургийн бичигт: Шавгайн Дашийн Бадамын Тавхааны Бүүвэй. Бүүвэйн Уранцэцэг гэж тэмдэглэсэн [Буриадын угийн бичиг. 2008:96].

² Бүүвэйн Уранцэцэг. 1951 онд төрсөн. Дорнод, Дашбалбар сум. Сэвсүүл-Жараахай баг. Урианхан (хасаг) хамниган, эмэгтэй.

үхэх болно. Ийм учраас овгийн нийгмүүдэд бороо хурыг урин дуудагч этгээд бол тун чухал хүн болж байв. Тэрбээр хэрэв хур бороо урин дуудахыг хүсэж буй бол ус шүрших, эсвэл, үүлийг даган дуурайх байдлаар үйлдэл гүйцэтгэдэг, харин тэрбээр бороо хурыг зогсоож, хэтэрхий ихэдсэн чийг усыг хатааж ууршуулахын тулд галын нөхцөл боломжийг ашигладаг” (Отгонбаяр, Vol.9, No, 18, p. 28) хэмээн гүн ухааны учир холбогдлыг тайлбарласантай язгуур утгаараа нэгдмэл бөгөөд монгол угсаатны домгийн сэтгэлгээ, тэнгэр шүтлэг, түүнээс үүссэн ритуал буюу зан үйл, соёл хэлэнд туссан нэг илрэл, хувилбар мөн гэж үзэж байна. Тодруулбал, Монгол угсаатан, түүний дотор хамниганы зарим овог малын дотор мах хүнсэнд хэрэглэх, идэхийг цээрлэдэг байсан заншлаа зөрчиж болохгүй, хэрэв зөрчвөл тэнгэрийн сумны аюултай ижил тэнцүү үзэж зүйрлэснээр энэ хэлц үг үүссэн байна. Тиймээс бүрэлдэхүүнд нь “ниргэ, ниргэнэ” гэсэн үг байдаг аж. Улмаар, нийт монгол угсаатны дунд “цээрийн ёс” болон дэлгэрсэн гэж үзэх бүрэн үндэстэй. Энэ үзэгдлийг тархалтын онол, соёлын тархалт (*diffusion of theory, cultural diffusion*), соёлоос зээлдэх (*acculturation*), бие даан бүтээх (*independent*)-ын арга зүйгээр тайлбарлаж болно. Нийгэм, соёлын хүн судлалын салбарт түлхүү ашигладаг, уг онолыг судалгаанд түгээмэл хэрэглэдэг бөгөөд аливаа нийгэм, угсаатны бүлэг, хувь хүний бүтээсэн соёл нөгөөд тодорхой байдлаар нөлөөлсөн, шинээр бий болсон тухай тайлбарладаг ажээ. Тэгэхээр, тус хэлц үг хамниганы болон халхын зарим угсаатны гарал үүсэл, тэнгэр шүтлэгийн улбаатай түүх домог, ахуй соёлын холбооноос улбаатай. Эдүгээ монголчуудын дунд цээрийн ёсны утга түлхүү илэрхийлэх болсон нь тархалтын онолоор тайлбарлах үзэгдэл мөн.

Монголчууд өдөр тутмын амьдралдаа хамаатай (аж ахуй, хувцас хэрэглэл, орон гэр зэрэг хийж бүтээсэн зүйл, тэдгээрийн бүрдэл хэсэг) цээрлэх ёс, бэлгэдэл, зан үйлийг бүтээсээр ирсэн. Жишээ нь: Таван хошуу малаа өсгөж үржүүлэх, эдэлж хэрэглэх, мах, сүү, түүхий эдийг нь боловсруулах, хадгалах, хоол хүнсэнд хэрхэн хэрэглэх талаар баримталж, мөрдөж ирсэн зан үйл, цээр, бэлгэдэл олон бий. Тухайлбал: “Малын мах нэгэнт зэрэг дугаартай учир хүүхэд, эмэгтэй хэн хүнгүй гар хүрдэггүй мах байдаг... *Нугалуур идвэл нутаг гүйнэ. Нугас чөмөг идвэл нусгай болно. Олгой идвэл олиггүй хүн болно. Тархи идвэл улцан болно*” гэх мэт хүүхэд, эмэгтэйчүүдэд хамаатай цээрийн ёс байна. Энэ бүгд өвгөд буурал, эр нөхрөө хүндэтгэх заншил, хүү охины эрүүл мэндэд холбоотой байх магадгүй (Нямбуу, 2023, p. 43); “*Сархинаг идвэл салан болно*” гэсэн хэлц үгийг хуримын зан үйлийн нэг үүдэн дарлага хийх ёс бий болсон домгоор тайлбарласан байна (Монсудар, 2011, p. 133). Өгүүлбэрийн бүтэц, хэлбэрийн хувьд “*Дэлүү идвэл дэлбэ ниргэнэ. Олгой идвэл олби ниргэнэ*” гэсэн хэлц үгтэй гишүүдийн тоо, айзам хэмнэлээр адил төсөөт өгүүлбэрээс бүтсэн. Утгын орны талаас малын дотор махны нэгийг өгүүлжээ. Бүтэц, хэлбэрийн талаас заримдаг төсөөт хэллэг ч бас байна. Тухайлбал: “*Дэлбэ алгадаж, дэлүү наах. Шалба алгадаж, шавар наах*” гэсэн хэлц үгийн хувьд дээрхээс бага зэрэг ялгаатай утгаар, өөр орчин нөхцөлд ямар нэг ажил үйл гүйцэтгэх үед хэлэлцдэг үг болов уу. Тус судалгаан дахь “дэлүү”-нд холбогдох, идээ ундны соёл, цээрийн ёс (хүүхдэд хамаатай), бэлгэдлийн утга илэрхийлсэн хэлц үг олныг нэрлэж болно. Эдгээрийн талаар товч өгүүлсэн өмнөх судалгаанаас үзэж болох юм. (Цэрэнчимэд, 2024)

Ямартаа ч тус судалгаа болон өмнөх судалгаанд ажигласан “дэлүү” гэх үг бүхий хэлц үг, хэллэгийн утгыг ерөнхийд нь:

а. *дэлбэрэх, ниргэх, дэлбэ, салба, шалба;*

б. *хөхрөх, даарах зутрах, цөөрөх багасах* гэж зааглаж болмоор байгаа нь сонирхолтой бөгөөд анхдагч утгаас салбарлан, утга өргөжихийн хамт ялгаатай зан үйл, үнэлэмж бүрэлдэж, хэвшсэн байх магадлалтай юм. Эдгээрийн учир холбогдлыг тусгайлан үзэж, нийт монгол угсаатны дунд дэлгэрсэн нийтлэг болоод өвөрмөц онцлогийг тодруулах нь бидний дараагийн судалгааны зохих хэсэг болно.

Дүгнэлт

Монгол угсаатны зарим овгийн эдийн соёл, оюуны соёлын илрэл болох шүтлэг бишрэл, угсаатны соёл-заншлын аман домгийн холбооноос хэвшиж тогтсон үг, хэллэг эдүгээ гол төлөв цээрлэх ёс, бэлгэдлийн утга илэрхийлдэг хэлц үг болж дэлгэрсэн нь судалгааны ажиглалт, үр дүнгээс харагдав.

Угсаатны соёлын өвөрмөц зан үйл, түүнээс улбаатай тус хэлц үгийн үүсэл нь хамниган угсаатны нэрийн тайлбар, зарим овгийн тэнгэр шүтлэгт хамаатай болох нь судалгааны баримтаар батлагдаж байна. Энэхүү хэлц үг хөгжлийн урт удаан хугацаанд бусад угсаатны заншил, соёлд зохих байдлаар нөлөөлж, ижил төстэй хийгээд өвөрмөц сонин үг, хэллэгүүд хэвшиж, янз бүрийн утгаар хэлэлцэх болсон магадтай тул хэлний баримт, соёлын эх сурвалжийг судалж, цогцоор авч үзэх нь зүйтэй.

Технологийн дэвшил, даяаршил нүүдлийн соёлд хүчтэй нөлөөлж буй энэ цаг үед угсаатны бүлгийн зан үйлийн зарим нь мартагдаж, хэзээ, хэрхэн бий болсон учир шалтгаан тодорхойгүй болж байна. Цаашид малын “дэлүү”-нд хамаарах нутаг, нутгийн зан үйл, уламжлалын бүх л талыг хэл-соёлын холбоонд нь угсаа хэл шинжлэлийн онол, арга зүйгээр тайлбарлах, тодруулах нь судалгаа, шинжилгээний чухал ач холбогдолтой болно.

An Ethnolinguistic Analysis of the Meaning and Cultural Features of the Idiom “Deluu idvel delbe nirge”

Tserenchimed Luvsantseren 

Ph.D, Department of Mongolian Language, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Abstract

This article seeks to analyze the meaning and cultural significance of the idiom *'de.lo: 'it.wəl 'del.pə 'nir.ge* a commonly discussed expression among Mongolians, along with its variants, using ethnolinguistic theory and methodology. The scope of this study is defined by a focus on this idiom and related expressions. Our analysis is based on field study notes collected by ethnographers, records of Mongolian customs, and examples from dictionaries, all of which are essential for testing our hypothesis through comparison and synthesis of the available data. By examining specific linguistic phenomena, we can find insights into the culture, historical events, political relationships, and oral traditions that shape ethnic groups. In exploring national and ethnic languages through an ethnolinguistic lens, we focus on the interplay between linguistic and non-linguistic factors. Indeed, non-linguistic influences, such as the *historical origins and history* of the ethnic group are especially significant in elucidating the meaning and cultural characteristics of the idioms under study.

This study draws on research materials, dictionaries, ritual glossaries, and prior studies on the topic of taboo, supplemented by case studies focusing on ethno-linguistic communication. There is a pressing need to examine specific linguistic and dialectal phenomena from an ethnolinguistic perspective. Future research should aim to explore the customs and traditions related to the concept of ‘spleen’ across various regions, not merely through the lens of idiomatic expressions, but to identify both the unique and shared characteristics of ethnic cultures.

Keyword: *ethnic language—culture, taboo, nomadic culture, ethnic tribe names*

НОМ ЗҮЙ

Батчулуун, Е. (1998). *Физик газар зүйн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар.

- Баянсан, Ж. (2022). *Монгол хэл судлал. Танихуйн хэл шинжлэл, Хэлний соёл судлал. Боть 14.* Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Бум-Очир, Д., Мөнх-Эрдэнэ, Г. (2018). *Нийгэм соёлын антропологиин онолын үүд.* Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр.
- Герд, А. (2005). *Введение в этнолингвистику.* Санкт-Петербург: Издательство СБГУ.
- Е.Батчулуун. (1998). *Физик газар зүйн нэр томъёоны тайлбар толь.* Улаанбаатар.
- Лувсанцэрэн, Б. (2008). *Буриадын угийн бичиг.* Чойбалсан: Нутгийн иргэдийн хөгжлийн төв хэвлэх цех.
- Монсудар. (2011). *Монгол хэлний хэвшмэл хэлцийн толь. Эрхэлсэн С. Чулуунпүрэв, Б. Одончимэг.* Улаанбаатар: Адмон.
- Мөнх-Эрдэнэ Г., Чулуунбат П. (2024). *Нийгэм соёлын хүн судлалын удиртгал. Хоёрдугаар хэвлэл.* Улаанбатаар: МУИС хэвлэлийн газар.
- Нандинбилэг, Г., Дулам, С. (2020). *Монгол аман зохиолын онол. Боть II. Хүүрнэн өгүүлэх аман зохиол. Жүжиг наадмын аман зохиол.* Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Нацагдорж, Б. (2021). Монголчуудын доторх тэнгэр дуудаачин нарын тухай. *Ethnologica Instituti Historiae et Ethnologici Academiae Scientiarum Mongoli. Tomus XXIX. Fasciculus 7.*, 102-124.
- Нямбуу, Х. (2023). *Монгол ёс заншлын их тайлбар толь. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. Ү боть.* Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Отгонбаяр, Ж. (Vol.9, No, 18). Үнэлэмжийн онол: домог зүйн хүн судлал. *Journal of Humanities and Social Sciences*, 25-30. <https://doi.org/10.69542/mjhss.v9i18.3696>
- Ренчин, Б. (1979). *Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас.* Улаанбаатар: БНМАУ. Сайд нарын зөвлөлийн барилга-архитектурын комиссын харъяа улсын геодези, зураг зүйн газар.
- Ринчен, Б. (1968). *Монгол Ард Улсын хамниган аялгуу.* Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн хэвлэл.
- Руденко, Е. (2014). *Этнолингвистика без границ. Введение в лингвистическую антропологию.* Минск: Белорусский Государственный Университет.
- Тангад, Д. (2014). *Монголын угсаатны зүйн хээрийн судалгаа. III боть.* Улаанбаатар: Мөнхийн Үсэг.
- Тангад, Д. (2014). *Монголын угсаатны зүйн хээрийн судалгаа. IV боть.* Улаанбаатар: Мөнхийн Үсэг.
- Толстой Н.И., Толстая С.М. (2013). *Славянская этнолингвистика: вопросы теории.* Москва: Институт славяноведения РАН.
- Хроленко, А. (2012). *Введение в этнолингвистику.* Курск: Издательство КГУ.
- Цэрэнчимэд, Л. (2024). Монгол угсаатны дэлүүтэй холбоотой зан үйл ба хэл, соёлын онцлог. *ГУМАНИТАРНОЕ ОБРАЗОВАНИЕ В СОВРЕМЕННЫХ УСЛОВИЯХ* (pp. 103-110). Улан-Удэ: Бурятского госуниверситета имени Доржи Банзарова.

